

ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ

Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 11 дүгээр сарын 12-ний өдөр Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг тус тус баталж, Засгийн газрын бүтцэд Эдийн засаг, хөгжлийн яамыг шинээр байгуулсантай холбогдуулан “Хууль хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний тухай” Засгийн газрын 1 дүгээр сарын 6-ны өдрийн 14 дүгээр тогтоолыг баталсан.

Тус тогтоолоор Засгийн газрын тохируулагч агентлаг-Үндэсний хөгжлийн газрыг татан буулган, татан буугдсан Үндэсний хөгжлийн газрын байр, эд хөрөнгө архив, албан хэргийн материал, албан хаагчдыг орон тооны хамт Эдийн засаг, хөгжлийн яаманд шилжүүлэхээр шийдвэрлэсэн.

Түүнчлэн Засгийн газрын зарим гишүүдийн эрхлэх асуудалд өөрчлөлт орсонтой холбогдуулан Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Сангийн яам, Гадаад харилцааны яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Хүнс, хөдөө, аж ахуйн яам, Төрийн худалдан авах ажиллагааны газрын зарим нэгжийн чиг үүргийг Эдийн засаг, хөгжлийн яам хариуцан хэрэгжүүлэхээр болсон.

Үүнтэй холбогдуулан Үндэсний хөгжлийн газрын 55 албан хаагч, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 5 албан хаагч, Сангийн яамны- 21 албан хаагч, Төрийн худалдан авах, ажиллагааны газрын 2 албан хаагчийг тус тус эрхэлж байсан чиг үүргийн дагуу тус яаманд шилжүүлэн ажиллуулж байна. Нийт 110 орон тооноос Сул орон тоо-18, Хадгалагдаж байгаа орон тоо -9 байна.

№	Нэгжийн нэр	Хэлтэсийн нэр	Орон тоо
1	Удирдлага		3
2	Сайдын ажлын алба		3
3	Хөгжлийн нэгдсэн бодлогын газар	Хөгжлийн загвар, шинэтгэлийн хэлтэс	13
		Нийгмийн хөгжлийн бодлогын хэлтэс	

4	Макро эдийн засгийн бодлогын газар	Төлбөрийн тэнцлийн хэлтэс	14
5	Бүс нутас, аж үйлдвэрийн бодлогын газар		10
6	Хилийн боомтын хөгжил, чөлөөт бүсийн бодлогын газар		6
7	Хөрөнгө оруулалтын бодлогын газар	Төр хувийн хэвшлийн түншлэлийн хэлтэс	15
		Төслийн санхүүжилтийн хэлтэс	
		Хөрөнгө оруулалтын дэмжлэг, сурталчилгааны хэлтэс	
8	Худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газар		9
9	Хөгжлийн санхүүжилтийн бодлогын газар		6
10	Хөгжлийн судалгааны газар		5
11	Төрийн захиргааны удирдлагын газар		21

----2022 он----